

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2 Уурхайн нөөц	4
1.2.1 Уурхайн хүчин чадал болон ашиглалтын хугацаа	4
1.2.2 Уурхайн ажиллах горим	4
1.2.3 Ашиглалтын систем	5
1.2.4 Уурхайн тоног төхөөрөмж	5
1.2.5 Баяжуулалтын технологи	6
1.2.6 2025 оны уулын ажлын хэмжээ	7
1.3 Дэд бүтэц	9
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	11
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	15
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /2025 ОН/	18
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	19
4.2 Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө	23
4.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	24
4.4 Түүх, соёлыг өвийг хамгаалах төлөвлөгөө	24
4.5 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	24
4.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	26
4.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	27
4.8 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	29
4.9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	33
4.10 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	34

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилцол	3
Хүснэгт 2. Ил уурхайн ажлын горим	4
Хүснэгт 3. Экскаваторуудын техникийн үзүүлэлт	6
Хүснэгт 4. 2025 оны бүтээгдэхүүн гаргалт, борлуулалт	8
Хүснэгт 5 талбайн ургамлын зүйлийн бичиглэл	12
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	
Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	23
Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	25
Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	26
Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	27
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	30
Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө	33
Хүснэгт 13. Бомт, түүний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө	34
Хүснэгт 14. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	35

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: “Хөх дэл” хайлуур жоншны ордын “Төв бүс”-ийн хэсгийг ил уурхайн аргаар ашиглах төсөл
Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-004306


Төсөл хэрэгжүүлэгч: “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ
Улсын бүртгэлийн дугаар: 9013001062
Регистрийн дугаар: 2550466
Хаяг: Улаанбаатар, Баянзүрх, 22-р хороо, өөрийн байр

Төслийн байршил: “Хөх дэл” хайлуур жоншны ордын “Төв бүс”-ийн хэсгийг ил уурхайн аргаар ашиглах төслийн талбай нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших Хөх дэлийн жоншны орд газарт MV-004306 тусгай зөвшөөрөлтэй Төв үнэгтийн 92.49 га талбайтай. Тус орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт тус сумын төвөөс урагш 25 км, аймгийн төв Мандалговиос 150 км, Бор-Өндөр УБҮ-ийн төмөр замаас 170 км зайд оршдог.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилцол

№	Уртраг	Өргөрөг
1	107° 57' 26.5"	45° 30' 43.62"
2	107° 57' 26.5"	45° 31' 3.62"
3	107° 56' 17.51"	45° 31' 3.62"
4	107° 56' 17.51"	45° 30' 43.62"

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 1. Төслийн талбайн байршил

1.2 Уурхайн нөөц

Хөх дэлийн ордод Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 01 дугаар сарын 29-ний Дугаар 02-3 тоот дүгнэлт, Ашигт малтмалын газрын даргын 2008 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Дугаар 46 тоот тушаалаар нийт бодитой В зэргээр 899.4 мян.тн хүдэрт 370.9 мян.тн эрдэс, боломжтой С зэргээр 519.6 мян.тн хүдэрт 203.8 мян.тн эрдсийн нөөц тус тус бүртгэгджээ. Үүнээс төв бүсийн хэсэгт боломжтой С зэргээр 213 мян.тн хүдрийн нөөц тогтоогдсон.

1.2.1 Уурхайн хүчин чадал болон ашиглалтын хугацаа

Уурхай нь жилд 35.0 мян.тн-ын хүчин чадалтай. Уурхайн ашиглалтын хугацаанд нийт 652.5 мян.м³ хөрс хуулж, 93 мян.тн хүдэр олборлоно.

1.2.2 Уурхайн ажиллах горим

Уулын ажил нь жилд 8 сар явагдана. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 10 цагаар, жилд 220 хоног ажиллана.

Хүснэгт 2. Ил уурхайн ажлын горим

Үзүүлэлт	Х.нэгж	Хоног
Календарь хоног	хоног	240
Жилд ажиллах сар	сар	8

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10
Ээлжийн тоо	ээлж	2
Ээлжинд ажиллах цаг	цаг	12
Баяр ёслолын хоног	хоног	10
Цаг агаарын саатал	хоног	8
Бэлтгэл ажлын хоног	хоног	2
Жилд ажиллах хугацаа	хоног	220

1.2.3 Ашиглалтын систем

Ордын геологийн тогтоц, геометр зүйн элементүүдийн хэмжигдэхүүнүүд харгалзан ил аргаар, экскаватор-автосамосвалын хослол бүхий тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр олборлоно.

1.2.4 Уурхайн тоног төхөөрөмж

Дотоод тээвэрт БНХАУ-д үйлдвэрлэсэн 25 тн-ийн даацтай HOWO загварын автосамосвал ашиглахаар төлөвлөсөн. Бас дээр нь уурхайн овоолгын ажилд SD23 маркийн бульдозер ашиглана.

Бутлан ангилах хэсгийн тоног төхөөрөмжийн сонголтыг хийхдээ дараах үндсэн зарчмуудыг баримталсан. Үүнд:

- Технологийн тооцооллын үр дүн
- Тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, засвар үйлчилгээний хялбар нөхцөлийг хангасан
- Тоног төхөөрөмжийн эдэлгээ удаан, сэлбэг хэрэгслийн олдоц сайн



Зураг 2. Уурхайн тоног төхөөрөмж

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 3. Экскаваторуудын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд		х.н	DX700LC	DX370LC-7
1	Утгуурын багтаамж		м ³	2.5-4.5	1.5-26
2	Стандарт утгуур		м ³	3.0	2.0
3	Хөдөлгүүр		-	ISUZU AH-6WGIXYSC-01	ISUZU GY-2543L
4	Хөдөлгүүрийн чадал		кВт	345.0	120.0
5	Ухах хүч		кН	360.0	250.0
6	Масс		тн	70.1	59.0
7	Түлшний савны багтаамж		литр	850.0	650.0
8	Овор	Урт	мм	13,250.0	11,200.0
9		Өргөн	мм	3,560.0	3,150.0
10		Өндөр	мм	4,220.0	3,890.0
11	Утгалтын хамгийн их гүн		мм	8,200.0	6,370.0
12	Утгалтын хамгийн их радиус		мм	11,500.0	9,070.0
13	Утгалтын хамгийн их өндөр		мм	8,410.0	7,530.0
14	Асгалтын хамгийн их өндөр		мм	8,320.0	8,020.0
15	Арын эргэлтийн радиус		мм	4,090.0	3,750.0
16	Хөдөлгөөний хурд		км/цаг	4-6	6-8


1.2.5 Баяжуулалтын технологи

Баяжуулах хэсгийн хүчин чадлыг ил уурхайн хүчин чадал түүний дагуу 200 мян.тн хүдэр баяжуулахаар төсөлд тусгасан. Жижиг уурхайнуудын хувьд флотацийн баяжмал ФФ 90 А-г гарган авах флотацийн үйлдвэр байгуулж, баяжуулалт хийх боломжгүйгээс гадна эдийн засгийн үр ашиг багатай тул гар ялгалтаар агуулга ихтэй хүдрийг ялган авах технологийн схемийг сонгож, холбогдох тоо чанарын тооцооллуудыг хийлээ.

"Эрдэнэс Критикал Минералс" ТӨҮГ-ын жоншны гар ялгалтын үйлдвэрийг жилд дунджаар 35 мян.тн хүдрийг уурхайгаас олборлон, гар ялгалтаар ялган ФК-75 маркийн баяжмал гарган авах хүчин чадалтай байхаар төлөвлөсөн.

-35мм ширхэглэлтэй дундаж агуулга 30.33% завсрын бүтээгдэхүүн гарган авч флотацаар баяжуулах бүрэн боломжтой байна.

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 3. Гар ялгалтын технологийн схем

Хүдрийг гараар ялгахад хүдрийн ширхэглэлийн хэмжээ 35-250 мм байх шаардлагатай байдаг бөгөөд “Хөх дэл” ордын хувьд гар ялгалтын аргаар хүдрийг ялган авах юм. Үүний тулд хүдрийн ширхэглэлийн хэмжээг багасгах зорилгоор бутлалтыг хийх ба энэ нь хүдэр боловсруулалтын бэлтгэл ажиллагаа болох юм. Хүдрийг буталж, шигшсэнээр ашигт бүрдлүүд нь хоосон чулуулгуудаас салахаас гадна ширхэглэлийн хувьд жигдэрч өгдөг. Иймээс ашигт малтмалыг баяжуулахын өмнө заавал буталж, шигших шаардлагатай. Хайлуур жоншны хүдэр нь хатуулаг багатай (Моосын шатлалаар 4) тул ихэвчлэн 1- шатны бутлалт, шигшилтын хосолсон схемээр хүдрийг баяжуулалтад бэлтгэдэг. “Хөх дэл” ордын хайлуур жоншны хүдрийн бутлалтад орох хүдрийн хамгийн том ширхэглэлийн хэмжээ -250 мм хэмжээтэй ирэх бөгөөд 1 шатны бутлалтад оруулж, /-150мм+35/, /-35мм/ гэсэн 2 ангилалд 1 тор бүхий чичиргээт шигшүүрээр шигшинэ.

1.2.6 2025 оны уулын ажлын хэмжээ

Уурхай нь 2025 онд 325.0 мян.м³ хөрс хуулж овоолго №1-д байршуулна. Хөрс хуулалтын ажлыг “Стандарт Алт Монгол” ХХК нь гэрээний дагуу өөрийн техникүүдээр хийж гүйцэтгэнэ.

Ухаж-ачих процессд техникийн даалгаврын дагуу Хөх дэлийн ордод Hyundai 520LC экскаватор ашиглахаар тусгалаа. Хөрс тээвэрлэлт замын дундаж зайг оруулан дунджаар 0.8-1.2 км зайнд байрлах гадаад овоолгод тээвэрлэнэ.


Хүдрийн дотоод овоолго тээвэр: Жилд дунджаар 15.0 мян.м³ буюу 35 мян.тн хүдрийг мөргөцгөөс шууд ачиж, хүдэр буулгах талбай хүртэл 1.0 км зайд тээвэрлэнэ.

Уурхай дээр дотоод тээвэрт HOWO 25 маркийн автосамосвалыг ТЭЗҮ-ний дагуу ашиглахаар төлөвлөсөн.

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 4. 2025 оны бүтээгдэхүүн гаргалт, борлуулалт

№	Үзүүлэлт	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Хөрс хуулалт		мян.м ³	325.0
2	Тухайн жилийн олборлолт	Хүдэр элс олборлолт		35.0
3	Тухайн жилийн боловсруулалт	Хүдэр элс боловсруулалт		59.8
4	Бүтээгдэхүүн гаргалт	Хайлуур жоншны хүдэр	мян.тн	60.1
5	Нийт борлуулалт	Хайлуур жоншны хүдэр	мян.тн	45.7



Зураг 4. Хөх дэл хайлуур жоншны уурхайн 2025 оны төлөвлөлтийн зураг

1.3 Дэд бүтэц

Уурхайн барилга байгууламж: Уурхай, үйлдвэрийн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр, агуулах-засварын байр багтах бөгөөд эдгээр нь уурхайн зүүн талд байрлана.



Зураг 5. Уурхайн кемп

Цахилгаан хангамж: Уурхайн нийт цахилгааны хэрэглээг 50 кВт болон 160 кВт-ийн чадалтай дизель үүсгэврээр хангахаар төлөвлөсөн. Уурхайд бутлан ялгах хэсэг, ил уурхайн гэрэлтүүлэг, хотхоны гэсэн цахилгаан хэрэглэгч байна.



Зураг 6. MP-212C-60 маркийн дизель генератор

Усан хангамж: Үйлдвэрлэлийн технологид ус ашиглахгүй бөгөөд зөвхөн ажилчдын унд ахуй, авто замын тоосжилт дарах, болон нөхөн сэргээлтэд ус ашиглана. Унд ахуйн болон тоосжилт дарах нөхөн сэргээлтийн усыг өөрийн эзэмшлийн худгаас зөөврөөр хангана.

Усны эх үүсвэр:

- Өрөмдмөл гүний худаг
- Усны ундарга 15 л/сек

Уурхайн ашиглалтын хүрээнд дараах усны хэрэглэгч байна. Үүнд:

- Ажилчдын унд ахуйн хэрэглээ
- Уурхайн зам талбайн тоосжилт
- Нөхөн сэргээлт

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүйн нөхцөл: Ордын талбай нь газар зүйн мужлалын хувьд Хэнтийн уулархаг хэсгээс говьд шилжих шилжилтийн хэсэгт багтах бөгөөд Дундад халхын өндөрлөг газарт хамаарагдана. Ийм учраас гадаргын хувьд намхавтар, нам дов толгодорхог, талархаг рельефтэй байдаг байна. Гадарга нь бөмбөгөрдүү оройтой, налуу хажуутай жигд үргэлжилсэн маягийн толгодтой.


Сумын нутаг дэвсгэр нь дундаж ба нам уулс, тал хээрийн жижиг толгод бүхий гүвээрхэг, долгиорхог, тэгш тал газар, тэдгээрийн хоорондох нугархаг нам хотсуудаар тодорхойлогдоно. Тал хээрийн бүст орших учир хөрсний үржил шим харьцангуй муу, чийг бага учир газар тариалан, хадлангийн аж ахуй эрхлэх боломж хязгаарлагдмал.

Төслийн талбай нь гадаргуугийн хувьд зүүнээсээ баруун тийш тусам өндөршсөн. Төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1100-1200 м-ийн өндөрт өргөгдсөн, газрын гадаргын хувьд, тал хээрийн жижиг толгод бүхий гүвээрхэг гадаргуутай байна.

Хөрс, хөрсөн бүрхэвч: Дундговь аймгийн Баянжаргалан сум нь хөрсний тархалтын хувьд хүрэн хөрс, цайвар хүрэн хөрс, цөлөрхөг хээрийн бор хөрс, хээржүү цөлийн бор хөрс зонхилж байдаг. Хөрс бий болох үйл явц нь хөрсний өнгөн давхарга дахь биологийн үйл явц зэргээр тодорхойлогдоно. Хөрсний өнгөн давхаргын жилийн дундаж температур $+4.7^{\circ}\text{C}$ байдаг ба зөвхөн өвлийн саруудад тэг градусаас доошилдог байна.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутгийн баруун урд хэсэгт монгол-оросын хамтарсан үйлдвэр “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ-ын хайлуур жоншны олборлолт явуулж байгаа газар Хөх дэл орчмын нутаг дэвсгэр нь хөрс, газар зүйн мужлалтаар Монгол орны Говийн их мужийн өргөрөгийн бүсчилийн цайвар хүн хөрсний дэд бүсийн Дундговийн 7-р тойрог, Баяндэлгэрийн 8-р тойргуудын зааг хэсэгт хамрагдана.

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 7. Хөрсний тархалтын зураг

Ургамлан нөмрөг: Ургамлын хэв шинжийн хувьд сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээрийн хэв шинжэд хамаардаг бөгөөд ургамлын зүйлийн бүрдэл 3-4 /хазаар өвс, таана, хялгана, аммоны сэдэргэнэ, гуу жалгаар алтан харгана/ зүйлийн ургамал тархсан эх газрын чулуулаг ил гарсан таана-хялганат бүлгэмдлийн хэв шинжтэй.

Хүснэгт 5 Талбайн ургамлын зүйлийн бичиглэл

Ургамлын нэр	Арви	Өндөр /см/	Хөгжлийн үе шат	Тайлбар
Таана / <i>Carex duriscula</i> /	Sp	25-30	Цэцэглэлт	Тайллагдсан
Хазаар өвс/ <i>Cleistogenes squarrosa</i> /	Sp	15-30	Цэцэглэлт	
Говийн хялгана / <i>Stipa gobica</i> /	Sp	20-35	Цэцэглэлт	
Аммоны эдэргэнэ / <i>Convolvulus ammannii</i> /	Sp	8-10	Цэцэглэлт	
Алтан харгана / <i>Caragana leucophloea</i> /	Sp	50-100	Цэцэглэлт	

ТӨСЛИЙН ТАЛБАЙН УРГАМАЛЖИЛТЫН АНГИЛАЛЫН ЗУРАГ

107°53'6"E 107°58'15"E 108°3'24"E

45°3'15"N 45°26'42"N

Багдуур-хялганат, багдуур-хялгана-тааанат

Хялгана-ерхөгст ба харгана, шарилж оролцсон хялгана-хазаар өвст

Үхэр харгана (дорнод хэсгээр), бүнгийн харгана (баруун хэсгээр) оролцсон хазаар өвс-хялганат

1231 m

Шарилж-хялгана-хазаар өвст, шарилж-монгол өвс-хазаар өвст

Хялгана-ерхөгст ба харгана, шарилж оролцсон хялгана-хазаар өвст

Зурман сүүлт (30%) ба нэг наст бударганат (20%) хиаг-уулалжтай дэрс

Алтан харгана оролцсон хазаар өвс-хялганат ба хялгана-хазаар өвс-шарилжит

Хиаг-уулалжит (20%) ба дэрс-хиаг-бударгатай (10%) хялгана-хиаг-алаг өвст бүлгэмдэл

Таних тэмдэг


MV-004306 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн хил

107°53'6"E 107°58'15"E 108°3'24"E

1:120,000

Усзүйн сүлжээ: Уг төслийн талбай нь Төв Азийн гадагш урсацгүй ай савын Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын хойт хэсэгт оршино. Төслийн талбайтай очиж танилцахад талбайн ойр орчим гадаргын ус буюу гол, горхи, булаг шанд байхгүй байсан. Уг сав газар нь ус зүйн сүлжээний нягтшил 0.01 км/м^2 -аас бага гадаргын усны эх үүсвэр хомс голчлон зуны хур борооны дараа түр зуурын урсацтай болдог цөөн тооны горхи, хуурай сайруудтай.

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 9. Гадаргын усны тархалтын зураг

Уур амьсгал: Монгол орны эрс тэс уур амьсгал хүчтэй мэдрэгдэх бөгөөд жилийн агаарын температур хэлбэлзэл нь 750 хүрэх бөгөөд өвөл агаарын температур - 40⁰С хүрдэг бол зун +35⁰С хүрнэ. Жилийн дундаж температур 0+2⁰С. Жилийн аль ч улиралд зонхилон баруун хойноос зүүн урагш чиглэлтэй салхитай байх ба дундаж хурд нь 15 м/сек, хамгийн их хурд нь 32 м/сек хүрдэг. Ихэвчлэн хавар, намар салхины хурд өндөр байдаг бол өвөл, зундаа харьцангуй бага. Энэ районд жилд дундажаар 120-150 мм орчим хур тунадас унадаг бөгөөд үүний ихэнх нь зуны сүүл намрын эхэн сард орно. Сүүлийн жилүүдэд харьцангуй агаарын темпуратур өөрчлөгдөж зундаа халуун, хур тунадас багатай гандуу, өвөлдөө хүйтэвтэр байх болсон.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ-ын Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Хөх дэл” хайлуур жоншны ордын “Төв бүс”-ийн хэсгийг ил уурхайн аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаа хэрэгжснээр тухайн бүс нутаг тодорхой хэмжээгээр элэгдэлд орно. Элэгдэл эвдрэлд оруулах гол хүчин зүйл нь авто машины хөдөлгөөнөөс тоос шороо, дуу чимээ үүсэх, барилга байгууламжийн нөлөөгөөр хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөг удаан хугацаанд дарагдах зэрэг юм.

Мөн төсөл хэрэгжсэнээр байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Агаарын чанар

- Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх
- Барилга байгууламжын орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх
- Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

Хөрсөн бүрхэвч

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах
- Ачиж тээвэрлэх үеийн машин техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх
- Машин техникийн эвдрэл гэмтэлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяаагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

Гадаргын болон газрын доорх ус

Төслийн талбайн хөрсөн дэх тоос нь хүчтэй хур борооны урсцаар дамжин хөрсний ус, хөрсийг бохирдуулах гол эх үүсвэр болно. Ялангуяа гадаргын усыг бохирдуулснаар цэвэр усны амьд организмыг хордуулах аюултай. Хөрсний усны бохирдлын байдлыг хяналтын цооног болон уурхайн худгийн усанд шинжилгээхийж байнгын хяналтад байлгавал зохино. Шинжилгээний дүнд усны чанарын үзүүлэлт зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн нөхцөлд мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор холбогдох арга хэмжээ авсны дараа үйлдвэрлэлээ үргэлжлүүлбэл зохино. Мөн уурхайн ахуйн бохир ус алдагдсанаас усны бохирдолд нөлөөлж болзошгүй тул энэ талын сөрөг нөлөөлөл үүсэхгүй байх арга хэмжээ авч хяналт тавьж ажиллах ёстой. Бохир усыг зөөж тээвэрлэх явцад асгаж хөрс бохирдуулах, мөн зөвшөөрөлгүй цэгт асгах зэрэг асуудал гарахаас урьдчилан сэргийлж ажиллавал зохино.

Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Уурхайн тээвэрлэлтийн тоосжилт, машин техникийн дуу шуугиан, доргио чичиргээ зэрэг нь ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж, тэдний ажиллах таагүй нөхцөлийг бүрдүүлдэг байна. Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосны 10 микроноос бага хэмжээтэй хэсгүүд нь хүний уушги болон амьсгалын замын эрхтнийг өвчлүүлэх гол эх үүсвэр болно. Удаан хугацаанд сөрөг нөлөөтэй орчинд ажилласнаас ажилчдын анхаарал сарних, осолд өртөх, элдэв өвчинд нэрвэгдэж, хөдөлмөрийн чадвараа түр буюу бүр мөсөн алдах зэргээр осол аюултай үр дагаврыг үзүүлнэ. Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөлийг шаардлагын хэмжээнд байлгаж чадсанаар ажиллагсдын мэргэжлээс шалтгаалах өвчлөл, хөдөлмөрийн чадвараа түр алдалт, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж чадна. Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөлд нөлөөлөх гол хүчин зүйлүүдийг 2 бүлэгт хувааж болно.

- Физикийн хүчин зүйл (температур, харьцангуй чийглэг, тоосжилт, дуу шуугиан, гэрэлтүүлэг г.м)
- Физиологийн хүчин зүйл (ажиллагсдын эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвараа түр алдалт)

Иймд физикийн хүчин зүйлүүдийг зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, ялангуяа тоосжилт ихтэй цехийн асперацийн системийн үйл ажиллагааг тогтворжуулах, агаар орчинд ус уур тоосруулан цацах маягаар тоосжилтыг багасгах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг иж бүрэн автомат удирдлагатай болгох зэрэг арга хэмжээ авахын зэрэгцээ мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллавал зохино.

Нийгэм эдийн засагт

Төсөл хэрэгжих суманд ажлын байр нэмэгдэх, орон нутгийн худалдан авалт сайжрах, төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмын албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу тооцоолон татвар хэлбэрээр улс болон орон нутгийн төсвийн санд оруулах, зэрэг ихэвчлэн эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтой байна. Гэхдээ төслийг хэрэгжүүлэх явцад байгаль хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх зэргээр орон нутгийн иргэдтэй үл ойлголцол бий болж болзошгүй тул төслийн явцад орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах хэрэгтэй.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /2025 ОН/

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/618 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг үндэслэл болголоо.

Байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх
- Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, төсөв, хэрэгжүүлэх хугацаа болон давтамжийг тусгаж өгөв.

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР ОРЧИН						
1.	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах	Уурхайн ашиглалтын талбайд	2,000.0	2025 онд	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2.		Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх, тоос дарагч бодис ашиглах	Уурхайн ашиглалтын талбайд	8,000.0	2025 онд	Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998
3.		Салхи, шуурга ихтэй үед хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг хязгаарлах	Уурхайн ашиглалтын талбайд	ҮАЗ-д тусгасан	Үйл ажиллагааны туршид	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.
4.		Тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засаж сайжруулах	Гадаад, дотоод тээврийн зам	1,000.0	2025 онд	Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
5.		Уурхайн машин механизмуудын янданд шүүлтүүр тавих	Төсөлд ашиглагдаж буй техник хэрэгслүүд	250,0	2025 онд	
6.		Тээвэрлэлтийн үед гарах тоос шороог багасгах үүднээс уурхайн дотоод болон гадаад замуудад хайрга чулуу дэвсэх	Уурхайн ашиглалтын талбайд	8,000.0	2025 онд	
7.		Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах сургалт явуулах	Уурхайн ажиллагсадад	250,0	2025 онд	
8.		Уурхайгаас дотоод гадаад тээврийн гол замын сүлжээ, маршрутыг тогтоох	Гадаад, дотоод тээврийн зам	ҮАЗ-д тусгасан	2025 онд	
9.		Ашиглагдаж буй машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, агаар бохирдуулсны төлбөрийг төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Төсөлд ашиглагдаж буй техник хэрэгслүүд	ҮАЗ-д тусгасан	Үйл ажиллагааны туршид	
Дүн				19,500.0		
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ						
10.	Газрын гадарга эвдэрч, Хөрсний үржил	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтанд хяналт тавих	Уурхайн хүрээнд	1,500.0	Тогтмол	Хөрс хамгаалах Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
11.	шим алдагдах, бохирдох, эвдрэх, доройтох	Хог хаягдлаар дамжин хөрсний бохирдол үүсгэхгүйн тул хог хаягдлын эцсийн цэгт хүргэх	Ахуйн хог хаягдлын цэг	Хог хаягдлын МТ-д тусгасан	2025 онд	Газрын тухай хуулийн 50.1.1 MNS5914:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
12.		Машин техникийг маршрутын замаар явахыг хянах, зураг төслөөс гадуурх хөрс, талбайг хөндөхгүй байх	Үйл ажиллагааны турш	ҮАЗ-д тусгасан	2025 онд	
13.		Машин механизмын засвар үйлчилгээ хийх талбайд бетон хучилт хийх	Уурхайн засварын талбай	3,000.0	2025 онд	
14.	Ургамлан нөмрөг талхлагдахаас сэргийлэх	Автомашины хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	Уурхайн дотоод, гадаад тээврийн зам	Үйл ажиллагааны зардлаар	2025 онд	“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал
Дүн				4,500.0		
ГАЗРЫН ДООРХ УС						
15.	Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг хэмжээгээр ашигласнаар усны нөөцөд сөргөөр нөлөөлөх	Талбайн хэмжээнд байрлах гүний худгуудад тогтмол горимын болон чанарын хяналт шинжилгээг явуулах	Уурхайн усан хангамж хангаж буй гүний худаг	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан	2025 онд	Усны тухай хууль: Зүйл 24-1.1, 1.2; Зүйл 30; Зүйл 31-1, 2, 3, 4, 5, 6, 8; Зүйл 33-1, 2, 3; Зүйл 34-1, 2; Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4596:1998. БОНБНУ, Компанийн дотоод журам,
16.		Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах	Усны хэрэглээгээр	ҮАЗ-д тусгасан	2025 онд	

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
17.	Газрын доорх ус	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах	Үйл ажиллагааны турш	Агаарын чанарын хэсэгт тусгасан	2025 онд	
Дүн				-		
НИЙТ				24.000,0		

4.2 Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө

Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /сая.төг/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг,стандарт аргачлал
1	Техникийн нөхөн сэргээлтийн гол зорилго нь биологийн нөхөн сэргээлт хийхэд зориулсан овоолгын талбайг	2025 онд биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийгдэхгүй болно.	га	-	-	-	2025 онд	MNS 5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
2	тэгшлэх, уурхайн ашиглагдсан орон зайг хөрс шороогоор		га	-	-	-	2025 онд	
3	дүүргэх, хэлбэржүүлэх зэргээр стандартын шаардлагын түвшинд засаж тэгшлэнэ.		га	-	-	-	2025 онд	
Нийт дүн			17.0					

4.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Төслийн MV-004306 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал байхгүй байна.

4.4 Түүх, соёлыг өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

4.5 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11 -д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /сая.төг/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
1	Мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, дүгнэлтийг үндэслэн зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлэх	Орон нутгийн саналын дагуу	-	-	2.0	2025 онд	
2	Орон нутгаас авсан саналын дагуу дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэх	Орон нутгийн саналын дагуу	-	-	2.0	2025 онд	
Нийт дүн, сая.төг				4.0			

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

4.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Дотоод журам	2025 онд
		500.0	2025 онд
	Гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр
	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр уурхай эхлэх үед
Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө
	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	500.0	Жил бүр, жилд 1 удаа
	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	1,000.0	Жил бүрийн I улиралд байрлуулан сар бүр шалгаж байх
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах -Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Сөрөг нөлөөллийг бууруулах зардалд тусгасан	Жил бүр, жилд 1 удаа
Нийт зардал		2,000.0	

4.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Энгийн хог хаягдлын ангилан ялгадаг хогийн савыг тавих	Уурхайн хотхон	500.0	Төслийн эхэн үед	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах	2,000.0	Төсөл хэрэгжих хугацаанд	
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх	ШТС, Ажилчдын байр	500.0	Төслийн эхэн үед	

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	500.0	Төслийн эхэн үед	Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хаягдал тосыг хуримтлуулах сав байрлуулах	Уурхайн ашиглалтын талбайд	500.0	Төслийн эхэн үед	
	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй тохижуулах	Зориулалтын хог хаягдлын цэг	ҮАЗ-д тусгасан	Төслийн эхэн үед	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
			4,000.0		

4.8 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчныг хамгаалан төлөвлөгөөтэй нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Хөрсний бохирдол						
1	Хөрсний агрохими хөрсний механик бүрэлдэхүүн	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт	Жилд 1 удаа 3 цэгт	300,0	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга,
2	Хөрсний хүнд металлын агууламж	Хөрс хүнд металлаар бохирдох, хөрс рүү нэвчих, гүний усыг бохирдуулах	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт	Жилд 1 удаа 3 цэгт	350,0	MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга
3	Хөрсний эрүүл ахуй, микробиологи	Хөрсөөр дамжин гэдэсний халдварт өвчин, нянгийн өвчнөөр өвчлөх	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт	Жилд 1 удаа 3 цэгт	300,0	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никелийг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
						MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
НИЙТ 950.0						
Усны хяналт шинжилгээ						
2.1	Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий шинжилгээ	Гүний худаг	Унд ахуйн ус хангаж буй гүний худаг	Жилд 1 удаа	350,0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж
2.2	Усны чанар Микробиологи	Усны эрүүл ахуйн шинжилгээ		Жилд 1 удаа	400,0	MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
НИЙТ 750.0						
Ургамлын аймаг						
3.1	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамлын судалгаа	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө, шинэ газар хөндөгдөх болгонд	Төслийн талбай	Жилд 1 удаа	1.300,0	Байгаль орчны мэргэжилтэн, ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					3,000.0 мян.төг	

4.9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах	Үйл ажиллагааны хүрээнд	1.0	2025	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	Үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ-д тусгасан	2025	Уурхайн дотоод журам
Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ-д тусгасан	2025	Уурхайн дотоод журам
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл	Үйл ажиллагааны хүрээнд	1.0	2025	Байгаль орчныг хамгаалах тухай хууль

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх				
Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Нийгмийн хариуцлагын хүрээнд	3.0	Төслийн хугацаанд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Нийт, сая.төг	5.0			

4.10 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ. Тус хэлэлцүүлгийг жил бүр 10-р сард зохион байгуулах ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хэлэлцүүлгийн үр дүнг оруулна.

Хүснэгт 13. БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
БОУАӨЯ болон Дундговь аймгийн Байгаль орчны газарт	Цахимаар	Тухайн жилийн БОМТ-ийн хэрэгжилтийн тайлан	11-р сар	-	-

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “ТӨВ БҮС”-ИЙН ХЭСГИЙГ ИЛ
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 14. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Жилийн зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан/	төгрөг	24,000,000
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	төгрөг	17,000,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	4,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төгрөг	2,000,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	төгрөг	4,000,000
8	Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө	төгрөг	5,000,000
9	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	төгрөг	3,000,000
10	БОМТ -г орон нутагт тайлагнах	төгрөг	-
Дүн		төгрөг	59,000,000